

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 01 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

Цагдаагийн байгууллага 2017 онд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд урьд онуудад хийгдсэн хэрэглэгчийн үнэлгээ, дэвшүүлсэн зорилт, эрсдэлийн үнэлгээний тайлан, түүний хэрэгжилт, алба нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн санал зэргийг судлан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх”, “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх”, “Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах” гэсэн зорилтуудыг дэвшүүлэн, үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтын шалгуур үзүүлэлтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/34 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж, ажиллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/, Дотоодын цэргийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэлэлцэгдэн батлагдсан.

Шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад орох өөрчлөлт, санхүүгийн үйл ажиллагаанд учрах хүндрэл болон журам, заавруудыг шинэчлэн, нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж, үр дүнг тооцсон.

Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хуулийн эх бичвэрийг хүлээн авах, байлдааны туг залах ёслолын ажиллагааг 2017 оны 03 дугаар сарын 21, 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын тангараг өргүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 76 дугаар тогтоолоор Цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, батлах тухай” А/262 дугаар тушаал батлагдан, уг тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/55 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын цагдаагийн газар”-ыг “Нийслэлийн цагдаагийн газар”, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Захиргааны удирдлагын газар, Урьдчилан сэргийлэх хэлтсийг шинээр байгуулж, Төрийн нууц, шифр харилцааны тасгийг Төрийн

нууцын хэлтэс болгон өргөжүүлж, Эрүү, Мөрдөн, Хэрэг бүртгэх, Санхүү, хангамжийн газрыг “Алба”, “Техникийн газрыг Тусгай газар, Лицензийн төвийг Бүртгэл, хяналтын төв, Сургалтын нэгдсэн төвийг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв болгон зарим бүтцийн нэгжийн болон ажлын байр /албан тушаал/-ны нэр, нэршлийг өөрчилсөн.

Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/134, А/135 дугаар тушаалаар Нийслэлийн цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтэс болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг тус тус баталж, зарим бүтцийн нэгжийн болон ажлын байр /албан тушаал/-ны нэр, нэршлийг өөрчилж, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч мөрдөн шалгах ажиллагааг явуулж “Мөрдөгч” гэсэн нэршилтэй байхаар, Зөрчлийн тухай хуулиар цагдаагийн байгууллагад харьяалуулсан зөрчилд Хэрэг бүртгэх алба, Замын цагдаагийн алба зөрчлийн хэрэг бүртгэлт явуулахаар тусгасан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэст “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг”, Нийслэлийн цагдаагийн газарт “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс”, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газарт гэрээт цагдаагийн тасгийг тус тус байгуулж, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Сайхан сум дахь сум дундын цагдаагийн тасаг, Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын Бор-Өндөр сум дахь цагдаагийн тасгийг “Хэлтэс” болгон өөрчилсөн.

Дотоодын цэргийн тухай хууль энэ оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны Б/28 дугаар тушаалаар Дотоодын цэргийн штабын даргыг томилж, 2017 оны А/217 дугаар тушаалаар Дотоодын цэргийн бэлгэ тэмдэг, тугны загвар, хэрэглэх журам, Улсын ерөнхий прокурор, Дотоодын цэргийн командлагчийн 2017 оны А/111, А/187 дугаар хамтарсан тушаалаар Дотоодын цэргийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журам, 2017 оны мн/08 дугаар тушаалаар Дотоодын цэргийн зохион байгуулалтын бүтэц, Дотоодын цэргийн штабын албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг тус тус баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн Засгийн газрын 2017 оны мн/282, 283, 285 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн нийт бие бүрэлдэхүүний орон тооны дээд хязгаар”, “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”, “Дотоодын цэргийн цол, цалин, албаны нэмэгдлийн хувь хэмжээ”-г батлуулж, мөн оны 280 дугаар тогтоолоор дотоодын цэргийн 2 ангийг байгуулан, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын мөн оны н/90 дүгээр тушаалаар өмнө хэрэглэж байсан “Цэргийн ангийн захидал харилцааны дугаар”-ыг сэргээн олгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2017 оны А/204, А/205 дугаар тушаалаар 05 дугаар ангид “Байлдааны туг, одон, хүндэт нэр”, 805 дугаар ангид “Байлдааны туг”-ийг тус тус шилжүүлж, мөн оны Б/01 дүгээр тушаалаар офицер бүрэлдэхүүнийг, Дотоодын цэргийн штабын даргын 2017 оны Б/01, Б/02, Б/03 дугаар тушаалаар ахлагч бүрэлдэхүүнийг тус тус томилж, цэргийн цол олгов.

Дотоодын цэргийн командлагчийн 2017 оны А/04, А/05, А/06 дугаар тушаалаар Дотоодын цэргийн албаны үнэмлэхний загвар, Дотоодын цэргийн үйл ажиллагааны Хөдөлмөрийн дотоод журмын жагсаалт, код, Загвар, Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох журмууд, мөн онч мн/103, мн/109 дүгээр тушаалаар Дотоодын цэргийн албаны бэлэн байдлын удирдамж, төлөвлөгөө, Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд анги, тусгай салбаруудыг оролцуулах удирдамж, төлөвлөгөөг тус тус баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг /2017-2021 онд/ үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангах нь” сэдэвт үндэсний чуулга, уулзалтыг энэ оны 06 дугаар сарын 09-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулж, Монгол Улсын ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл зэрэг 800 орчим зочид, төлөөлөгч оролцсон.

Монгол Улсын Их Хурлын болон Хууль зүйн байнгын хорооны гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлагуудыг хүлээн авч, цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, учирч буй хүндрэл, бэрхшээлийн талаар танилцуулсан.

Тайлангийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаан 12 удаа хуралдаж, хуралдаанаас цагдаагийн байгууллагад цаг үеийн шинжтэй өгсөн 87 үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд тухай бүр хүргүүлсэн ба үүргийн биелэлт 98.5 хувьтай гарсан.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан мэдээллийг шуурхай солилцох, албаны бэлэн байдлыг хангах, цаг хугацаа, хөрөнгө хэмнэх, үүрэг даалгавар, тулгамдаж буй бусад асуудлыг харьяа нэгжүүдэд шууд хүргэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нартай дүрст /видео/ хурлыг 2 удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон. Цаашид энэ ажил, арга хэмжээг сар тутам зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн дээд байгууллагаас ирүүлж буй үүрэг, даалгавар, ажлын чиглэлийг шуурхай хэрэгжүүлэх, алба, нэгжийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан мэдээ, мэдээлэл солилцох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох зорилгоор харьяа алба, нэгжүүдийн удирдах ажилтнуудын мэдээлэл, харилцан солилцох хурлыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх үүрэг, ажлын чиглэлийг холбогдох нэгжүүдэд хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газраас бусад агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах 23 санамж бичиг, хамтын ажиллагааны 11 гэрээ байгуулснаас Авлигатай тэмцэх газар, Монгол Банк, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Нээлттэй нийгэм форум, Монголын оюутны холбоотой "Хамтран ажиллах санамж бичиг" шинээр, Хүний Эрхийн үндэсний комисстой байгуулсан "Санамж бичиг"-ийг 3 жилээр сунгаж, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай "Хамтран ажиллах гэрээ" тус тус байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оныг "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил" болгосонтой холбогдуулан, харьяа агентлаг, байгууллагуудын "Нээлттэй өдөрлөг" арга хэмжээг мөн оны 05 дугаар сарын 18-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр Цагдаагийн албаны тухай хууль, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй "Гэмт хэргийн хяналтын цогц систем", "Телекамер", "Эргүүл" дэд хөтөлбөр, Олон нийтийн цагдаа, Оюутан цагдаа, галт зэвсэг тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал, гэр бүлийн хүчирхийлэл,

халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг 12 төрлийн 3000 ширхэг сурталчилгааны материал, сэрэмжлүүлгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад тарааж, 658 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, 54 иргэний өргөдөл, материалыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлаа Иргэний зөвлөл, иргэдэд тайлагнах тайлангийн хуралд аймаг, нийслэл, дүүрэг, сум, баг, хороодын иргэдийг өргөнөөр хамруулах ажлын чиглэл өгч, Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүд, албадын дарга нарыг оролцуулж, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах ажлыг нэгдсэн байдлаар зохион байгууллаа.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний зөвлөлийн дүрэм”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж, тайлагнах талаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт үүрэг, ажлын чиглэл хүргүүлж, биелэлт үр дүнг тооцлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай, Цагдаагийн ерөнхий газрын даргаас даргын зөвлөлийн гишүүд, албад, харьяа нэгж, газар, хэлтсийн дарга нартай менежерийн 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулан биелэлт, үр дүнг тооцсон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд нийт 58 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс нийтлэг 28 ажил, арга хэмжээний хэрэгжилт 26.6, тусгай захиалгат 30 ажил, арга хэмжээний хэрэгжилт 34.0, манлайлал буюу мэдлэг чадвараа дээшлүүлэх 8 зорилтын хэрэгжилт 28.7, нийт 89.3 хувьтай дүгнэгдсэн ба үр дүнгийн гэрээг дүгнэсэн илтгэх хуудсыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01/71 дүгээр албан бичгээр Хууль, зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд 2 бодлогын баримт бичгийн биелэлт 100, 33 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт 98.6, 10 үндэсний хөтөлбөрийн биелэлт 82.0, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөний биелэлт 84.6 хувьтай тус тус үнэлэгдэж, Хууль зүй, дотоод хэргийн яам, баримт бичгийн хэрэгжилт хариуцсан байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх Эрх зүйн сургалт, сурталчилгааны дэд төлөвлөгөө, Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагад ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх чиглэлээр 2017 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагын дотоод аудит, Хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр хуралдаанаас агентлагийн дарга нарт даалгасан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон дээд шатны байгууллагаас батлан гаргасан холбогдох төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад салбар төлөвлөгөөг хүргүүлэн, үр дүнг тооцон ажилласан.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралдаанаар “Ухаалаг цагдаа” төслийн 2 дугаар шатанд хэрэгжих ажлуудтай танилцаж, хэв журмын 1500 урамшилт эргүүл, 224 олон нийтийн болон оюутан цагдаагийн үйл ажиллагаанд шаардагдах 3.6 тэрбум төгрөгийн төсвийг шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 62 дугаар тогтоолоор “Эргүүл”, “Телекамер”, “Гэмт хэргийн хяналтын цогц систем” дэд хөтөлбөрүүдийг батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

“Гэмт хэргийн хяналтын цогц систем” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийх, мэдээлэл нэгтгэн боловсруулах, удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий нэгдсэн хяналтын “Удирдлагын төв”-ийг байгуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Телекамер дэд хөтөлбөрийн хүрээнд иргэдийн идэвх санаачилгад суурилсан камержуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Камержуулалт аян” болзолт уралдааныг 2 сарын хугацаатай зохион байгуулж, нийслэлийн 15 хороо, Сууц өмчлөгчдийн 102 холбоо, хөршийн хяналтын 15 бүлэг, 108 иргэн оролцож, орон сууц түүний гадна орчин, гэр хорооллын гудамж, талбайд 534.431.328 төгрөгийн өртөг бүхий 2211 камер шинээр суурилуулсан.

Хүний нөөц, сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 13 удаагийн хуралдааны шийдвэрээр бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан 10372, шилжүүлэн буюу зохицуулан 976, бага бүрэлдэхүүнээс офицерын бүрэлдэхүүнд 298, офицер, дадлагажих ажилтнаар 37, хүүхэд асрах чөлөө цуцалсан 46, албан тушаал дэвшүүлсэн 487, үүнээс шинээр хэлтэс, газрын даргаар 86, нөөцөөс 34, шууд 10, Хууль сахиулахын их сургууль, ОХУ, Туркийн сургуулийн төгсөгч 7, эргүүлэн томилсон 4, албан тушаал бууруулан 65, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх 19, цуцалсан 9, бүлгийн цагдаагаар 4 алба хаагчийг тус тус томилсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 86 дугаар тогтоолын дагуу аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 78 алба хаагчид 30 сарын тэтгэмж, албан үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 60 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй ердийн өвчнөөр нас барсан 11 алба хаагчийн ар гэрт нөхөн олговор, 3 алба хаагчид буцалтгүй тусламж, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 200 алба хаагчид 36 сарын тэтгэмж, цэргийн байнгын тэтгэвэр хувь тэнцүүлэн тогтоолгосон 11 алба хаагчид 18 сарын тэтгэмж, цэргийн алба хаах насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 10 алба хаагчид цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сарын цалинтай тэнцэх хэмжээний ногдох хэсгийг урьдчилан, 15 алба хаагчид нөхөн олговор тус тус олгож, 536 алба хаагчийн цалингийн шатлал, нэмэгдлийг шинэчлэн тогтоож, 825 алба хаагчийг богино хугацааны сургалтад хамруулж, 12 алба хаагчид цалинтай, цалингүй чөлөө олгож, цагдаагийн хурандаа цолоор 27, цагдаагийн дэд хурандаа цолоор 101, цагдаагийн хошууч цолоор 153, цагдаагийн ахмад цолоор 342, цагдаагийн ахлах дэслэгч цолоор 462, цагдаагийн дэслэгч цолоор 205 алба хаагчийг шагнаж, бусад байгууллагаас халагдсан болон чөлөөлөгдсөн 16 алба хаагчийн албан тушаалын цолыг хурааж, шийдвэрлэсэн байна.

Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 140 алба хаагчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон медалиар, 348 алба хаагчийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар салбарын яамны шагналаар, 2651 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын шагналаар тус тус шагнаж, Хөдөлмөрийн тэргүүний алба хаагчаар 10, Ажил мэргэжлийн шилдэг алба хаагчаар 14, Оны онцлох алба хаагчаар 6 алба хаагчийг шалгаруулан, цагдаагийн байгууллагаас цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 58 ахмад ажилтныг шагнаж, урамшуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дахь хэсгийн 3.2.2-д заасны дагуу салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг 5 бүлэг, 29 заалттайгаар боловсруулж, 2017 оны 06 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлт 81.7 хувьтай дүгнэгдсэн.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох

иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын дагуу 2017 онд нийт 18 төрлийн 345 ажлын байрыг урьдчилсан байдлаар нээлттэй зарлаж, мэргэшлийн шалгалтыг 03, 09 дүгээр саруудад зохион байгуулж, ажлын байр/албан тушаал/-нд тавигдах ерөнхий болон тусгай шалгуурыг хангасан 1059 иргэнээс 616 иргэн шалгалтад тэнцэж, 442 иргэн Хууль сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуульд цагдаа, цагдаа-жолоочийн мэргэжлийн сургалтад хамрагдаж, цагдаагийн байгууллагад дахин орох 174 иргэнийг нөөцөд бүртгэсэн.

Дээрх салбар зөвлөлийн 2016 оны 13, 2017 оны 03, 12 дугаар тогтоолоор нөөцөд авагдсан иргэдээс нийт 579 иргэнийг цагдаагийн байгууллага дахь ажлын байр /албан тушаал/-ны сул орон тоонд томилсон байна.

Цагдаагийн алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарал хандуулж, "Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх" зорилтыг дэвшүүлэн ажилласан.

Цагдаагийн алба хаагчдын сургалтын эрэлт, хэрэгцээ, сахилга, ёс зүйн байдал, гадаад улс орнуудын цагдаагийн байгууллагын сургалтын төлөвлөлт, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн санал, гэмт хэргийн тоон мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын бодлого, чиглэл зэргийг судлан үзсэний үндсэн дээр шаардлагатай сургалтын цаг, сэдэв, төрлийг тогтоож, алба хаагчдад чиглэгдсэн богино хугацааны сургалт зохион байгуулахаар төлөвлөж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх "Цагдаагийн байгууллагын 2017 оны сургалтын хөтөлбөр"-ийг батлан хэрэгжилтийг хангалаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/211 дүгээр тушаалаар "Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журам"-ыг батлан мөрдөж байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн байгууллагын хэмжээнд давхардсан тоогоор 6568 удаагийн сургалт зохион байгуулагдаж, 274592 алба хаагч, 246786 иргэн хамрагдаж, 1528 алба хаагч боловсролын зэрэг ахиулах сургалтад суралцаж, 100 алба хаагч гадаад улс, оронд мэргэшил дээшлүүлж, туршлага судалсан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад явуулах сургалтын арга барил, төлөвлөлтийг өөрчлөх, сургалтын бодит мэдээллийг бий болгох, батлагдсан журмуудын уялдааг хангах зорилгоор сургалтын мэдээний хүснэгтийг шинээр боловсруулан алба, нэгжүүдэд хүргүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын захиалгаар Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академид "Цагдаагийн стратеги-тактик, удирдлага" мэргэжлийн болон "Хууль сахиулахуйн удирдлага" сургалтыг 5 алба хаагч төгсөж, 2 жилийн үндсэн сургалтад 6, "Хууль сахиулах захиргааны удирдлага" мэргэшүүлэх 1.5 жилийн хөтөлбөрт 1 алба хаагчийг тус тус суралцуулж байна.

Зохион байгуулсан сургалтаас дурдвал: Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг 2017 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлууд" сэдэвт онол, практикийн бага хурлыг мөн оны 04 дүгээр сарын ...-ны өдөр, цагдаагийн байгууллагын ахлагч бүрэлдэхүүний дунд "Цагдаа таны төлөө" сургалт, зөвлөгөөнийг мөн оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулж, 1100 ахлагчийг оролцуулж, Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу 44 сургагч ахлагчийг томилж, цол олголоо.

Шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, сургалт, сурталчилгаа хийх бэлтгэл ажлын хүрээнд энэ оны 06 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд 32 сургагч багш бэлтгэж, давхардсан тоогоор 2443 алба хаагчийг сургалтад хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-нд цагдаагийн байгууллагын удирдах ажилтнуудыг хариуцсан байгууллагынхаа эрсдэлийг тооцох, үйл ажиллагаандаа аудит, үнэлгээ, дүн шинжилгээ хийх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрийг чадавхжуулах зорилгоор “Эрсдэлийн удирдлага 1, 2”, “Хяналт шинжилгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлага 1, 2”, “Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах нь” сэдэвт сургалтуудыг тусгаж, 04 дүгээр сарын 07-ны өдөр харьяа алба, нэгжийн 60 удирдах ажилтныг хамруулсан.

“Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу 2017 онд “Олон нийтийн цагдаа” бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 51 иргэнийг хамруулан, гэрчилгээ олгосон ба олон нийтийн цагдаагийн сургалт, зөвлөгөөнийг 2017 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд зохион байгуулсан.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр: Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, айлчлал хийх, зохион байгуулах, мэндчилгээ дэвшүүлэх, судалгаа, мэдээлэл хүргүүлэх, мэдээлэл хүсэх, мэдээлэл солилцох чиглэлээр нийт 13 Элчин сайдын яам, 9 хууль сахиулах байгууллага, олон улсын 12 байгууллагатай харилцаа, холбоотой ажиллаа.

Гадаад улс орны цагдаагийн байгууллага болон олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзах 16 удаагийн уулзалт Монгол Улсад айлчилсан 9 удаагийн албаны айлчлалыг тус тус амжилттай зохион байгуулж, гадаад улс, орнуудад зохион байгуулагдсан 20 удаагийн сургалтад 103 айлчлал, албан томилолт, үзэсгэлэнд оролцохтой холбоотой 20 арга хэмжээнд 58, олон улсын хурал, уулзалтад оролцохтой холбоотой 18 арга хэмжээнд 23, нийт 58 арга хэмжээнд 184 алба хаагчийг гадаад томилолтоор Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар ажиллуулсан.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Масато Такаока, БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн суурин төлөөлөгч, БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны консул, цагдаагийн атташе Ким Дохан, АНУ-аас Бээжин хотод суугаа ЭСЯ дахь Холбооны мөрдөх товчооны Хуулийн дэд атташе Вирт Блейк, БНКУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Раул Делгадо Консепсион нартай хамтын ажиллагааны чиглэлээр уулзалт зохион байгуулж, харилцан санал солилцлоо.

Арабын Нэгдсэн Эмират Улсын нийслэл Абу Даби хотноо 2017 оны 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Аюулгүй байдлын төлөөх эв нэгдэл” сэдэвт олон улсын форумд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга нар, БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо 09 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын Ерөнхий ассамблейн 86 дугаар чуулганд Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах албаны дарга нар тус тус амжилттай оролцлоо.

Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засаг захиргааны дэд тэргүүлэгч бөгөөд Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн дарга Ма Мин тэргүүтэй төлөөлөгчдийг 2017 оны 08 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Монгол Улсын цагдаагийн байгууллагад айлчлах үеэр “Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгууллаа.

БНСУ-ын Ерөнхий прокурорын байгууллагаас Монгол Улсын цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 14.799 америк долларын санхүүжилтээр БНХАУ-аас шээснээс хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх Multi drug btesturinecup

(Heroin-MET-COC-AMP-THC-KET) тест 2845, шүлснээс хар тамхи мансууруулах бодис илрүүлэх Multi drug 3test panelsaliva (MOP-MET KET) тест 500 ширхгийг худалдан авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад тест ашиглах зааврын хамт хүргүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагаас Өмнөд Судан Улсад 2 алба хаагч 1 жилийн хугацаатай үүрэг гүйцэтгэж, 2017 оны 11 дүгээр сард эх орондоо ирсэн ба үүргээ амжилттай биелүүлсэн алба хаагчдыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны ... дугаар тушаалаар “Цагдаагийн гавьяа” тэмдгээр шагнаж, урамшуулсан. Хойд Судан Улсад үүрэг гүйцэтгэж байгаа 2 алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацааг тодорхой хугацаанд сунгуулах саналыг шийдвэрлүүлэн, алба хаагчид үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Байгууллагын хэмжээнд үйл ажиллагааны зохицуулалт, шуурхай байдал, архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, үйл ажиллагааны зохицуулалтаа боловсронгуй болголоо.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дотоодын цэргийн тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай хуулийн төсөл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, Улсын Их хурлын нэгдсэн чуулганаар тус тус батлуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгуулагдсан Өмгөөллийн тухай, Харьяатын тухай, Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх, хөдөлмөр хийлгэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт цагдаагийн байгууллагын алба хаагчид ажиллаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 8 эрх зүйн актын төсөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчаас ирүүлсэн 197 гомдол, санал, хүсэлтийн эрх зүйн зохицуулалтыг судалж, хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн дүгнэлт өгч, туслалцаа үзүүлсэн.

Тайлангийн хугацаанд эрүү, иргэн, захиргааны 50 хэрэгт хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, нэхэмжлэл, нотлох баримт хүргүүлж, 35 удаа давж заалдах болон хяналтын гомдол бичгээр гаргаж, шүүхээр шийдвэрлүүлсэн. Мөн Засгийн газрыг төлөөлж, 7 иргэний хэрэгт шүүхэд иргэний хариуцагчаар оролцож байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын 2016 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 4623 алба хаагчаар хуулийн хугацаанд гаргуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 32 алба хаагчаас гаргуулж, цахим системд бүртгэв.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр: Цагдаагийн байгууллагын хэмжээнд 1268 сахилгын зөрчилд 1277 алба хаагч холбогдсоны 810 буюу 63.4 хувь нь офицер, 467 буюу 36.6 хувь нь ахлагч бүрэлдэхүүн байна.

Нийт сахилгын зөрчлийг урьд оны мөн үетэй харьцуулбал зөрчлийн тоо 297 нэгжээр буюу 19.0 хувиар, алба хаагчийн тоо 312 буюу 19.3 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Нийт сахилгын зөрчлийн 579 буюу 45.7 хувь нь нийслэлд, 689 буюу 54.3 хувь нь орон нутагт бүртгэгдсэнээс 145 алба хаагч сахилгын зөрчил давтан гаргажээ.

Төрлөөр нь авч үзвэл: Хууль ёс, хүний эрх чөлөө зөрчсөн 31 буюу 2.4, ажлын хариуцлага алдсан 337 буюу 26.6, архидан согтуурсан 219 буюу 17.3, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 157 буюу 12.4, бусад хууль, тогтоомж зөрчсөн 69 буюу 5.4, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 220 буюу 17.4, үүрэг даалгавар үл биелүүлсэн 78 буюу 6.2, хээл хахууль, шан харамж авсан 5 буюу 0.4, бусад зөрчил 160 буюу 12.6 хувийг тус тус эзэлж байна.

Сахилгын шийтгэл ногдуулсан байдлыг авч үзвэл: сануулах шийтгэл 418 буюу 32.7, албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл 716 буюу 56.0, албан тушаал бууруулах шийтгэл 14 буюу 1.1, цагдаагийн цол бууруулах шийтгэл 26 буюу 2.0, цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл 103 буюу 8.1 хувийг тус тус эзэлж байна.

Нийт сахилгын шийтгэлийн 8.6 хувийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар, 87.9 хувийг тухайн байгууллагын даргын тушаалаар, 3.4 хувийг бусад байгууллагын даргын тушаалаар тус тус оногдуулсан.

Сахилгын зөрчлийн 79.0 хувийг дотоодын хяналтаар, 21.0 хувийг гадны хяналтаар илрүүлсэн бөгөөд урьд оны мөн үетэй харьцуулбал дотоод хяналтаар илрүүлсэн зөрчил 0.8 хувиар буурсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7-д "энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан цагдаагийн албаны сургалтын байгууллага шийтгэл хүлээсэн алба хаагчийн хамрагдах ёс зүйн сургалтыг цагдаагийн төв байгууллагын даргын баталсан үнэлгээний дагуу төлбөртэй явуулна" гэж заасны дагуу сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчдад ёс зүйн төлбөртэй сургалт явуулах журмыг баталж, 236 алба хаагчийг хамруулсан.

"Сахилгын зөвлөгөөн зохион байгуулах хуваарь, удирдамж"-ийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүдийг харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас зохион байгуулагдсан сахилгын зөвлөгөөнд хуваарийн дагуу оролцуулж, үр дүнг тооцсон.

"Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай" Цагдаагийн ерөнхий газрын даргын 01 дүгээр албан даалгаврыг баталж, харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласнаар алба хаагчдын гаргасан сахилгын зөрчил урьд оны мөн үеэс 19.0, зөрчилд холбогдсон алба хаагчдын тоо 19.3 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Тайлангийн хугацаанд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудад иргэд, байгууллагаас 11497 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг урьд оны мөн үетэй харьцуулахад 2191 нэгж буюу 23.5 хувиар өссөн.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 73 буюу 0.6 хувь нь санал, 11289 буюу 98.2 хувь нь өргөдөл, 135 буюу 1.2 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 1204 буюу 10.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 402 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1818 буюу 15.8 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 3152 буюу 27.4 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 654 буюу 5.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 4267 буюу 37.1 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11389 буюу 99.1 хувийг шийдвэрлэж, 108 буюу 0.9 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдээс Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 416 санал хүсэлт, өргөдөл гомдол, талархал, шүүмжлэл ирүүлсний 198 буюу 47.6 хувь нь санал хүсэлт, 165 буюу 39.7 хувь нь гомдол, 39 буюу 9.4 хувь нь талархал, 5 буюу 1.2 хувь нь шүүмжлэл, 9 буюу 2.1 хувь нь өргөдөл байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 327 буюу 78.6 хувийг шийдвэрлэж, 89 буюу 21.4 хувь нь ажиллагаанд байна. Хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 194 буюу 59.3 хувийг 5 хоногийн дотор, 133 буюу 40.7 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийг хангах талаар

Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх, техник технологийг шинэчлэх, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/24 дүгээр тушаалаар Урьдчилан сэргийлэх хэлтсийг байгуулж, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Мөн насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Урьдчилан сэргийлэх хэлтэст Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг, Нийслэлийн цагдаагийн газарт Хүүхдийг хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийг байгуулсан.

Тайлангийн хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн ажиллах журмыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/253, А/252 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагын 2017 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан 5 бүлэг, 51 заалттайгаар боловсруулж, улирал бүр биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 2017 онд 91.0 хувьтай дүгнэгдлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Цагдаагийн байгууллагад холбогдох заалтын биелэлт жилийн эцсийн байдлаар 92.0 хувьтай дүгнэгдсэнийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дагаж мөрдөгдөх Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон

холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, Аюулгүйн зэргийн үнэлгээ хийх, Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих, Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтаар хангах, Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журмын төслийг тус тус боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/25, А/26, А/29, А/37, А/38, А/39, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/65, А/35, Улсын ерөнхий прокурорын хамтарсан А/22, А/31 дүгээр тушаалуудаар тус тус батлуулан улсын хэмжээнд хэрэгжүүлж байна.

Тайлангийн хугацаанд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 3, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4, нийт 9 нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнд тухай бүр үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, холбогдохоос урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор улсын хэмжээнд “Хайрла-хамгаал” үндэсний аяныг 2017 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр: 613.4 тэрбум төгрөгийн хохиролтой, 11873 холбогдогчтой, 14332 хэрэг, үйлдлийг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 13046 материалыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шилжүүлсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад хохирол 503.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, холбогдогч 416 буюу 3.4 хувиар, нийт илрүүлсэн гэмт хэрэг, үйлдэл 769 буюу 5.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Интерполын А-7584/8-2017 дугаараар эрэн сурвалжлагдаж байсан БНКУ-ын 1 иргэнийг олж, тогтоон баривчилж, Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хооронд байгуулсан “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ”-ний дагуу шилжүүлэн өгсөн.

АНУ-ын “FMS Advanced Systems Group” компаний “Sentinel Visualizer 7.3, Professional Edition, Annual Support Contract for Sentinel Visualizer 7, Professional Edition” програм хангамжийн ашиглалтын эрх, тус програмыг ашиглахад шаардлага хангасан Dell-opt-5040 MT, Dell led-E2316 HV үзүүлэлт бүхий 2 ширхэг компьютер, цахим орчин дахь мэдээ, мэдээллийн түгээлт, тархалт, чиг хандлагыг эерэг, сөргөөр ялган дүн шинжилгээ хийх зориулалт бүхий “Кудос” програм хангамж зэргийг нийт 31.8 сая төгрөгөөр худалдан авах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын “Шилдэг хэсгийн төлөөлөгч” шалгаруулах уралдааныг зохион байгуулах ажлын хэсэг, уралдааны удирдамж, дүгнэх аргачлалын дагуу 3 үе шаттай хэрэгжүүлж, тэргүүн байранд шалгарсан алба хаагчийг УАЗ-469 маркийн автомашинаар, дэд байранд шалгарсан алба хаагчийг бүрэн тоноглол бүхий мотоциклоор, гутгаар байранд шалгарсан алба хаагчийг иж бүрэн компьютерээр тус тус шагнаж урамшуулсан.

Шинэчлэн батлагдсан хуулиудын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор “Гүйцэтгэх ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг улсын хэмжээнд бүсчлэн зохион байгуулах тухай” ЦЕГ-ын даргын 2017 оны мн/60 дугаар тушаалаар зүүн бүсийн сургалтыг Хэнтий аймаг дахь цагдаагийн газарт, баруун бүсийн сургалтыг Ховд аймаг дахь цагдаагийн газарт, хангайн бүсийн сургалтыг Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газарт 2017 оны 09 дүгээр сарын 11-30-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 318 алба хаагчийг хамрууллаа.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх зорилгоор хөтлөн ажиллуулдаг cybercrime@police.gov.mn цахим шуудан, “Цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба” нэртэй Фэйсбүүк хуудсанд иргэдээс ирүүлсэн 1563 санал хүсэлтэд хариу зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх чиглэлээр байршуулсан мэдээ, мэдээлэл 123,000 иргэнд хүрч, Фэйсбүүк хуудас 39756 иргэнд таалагдаж, 39,753 дагагчтай болж өссөн байна.

Мөрдөн байцаах албаны чиглэлээр: Тайлангийн хугацаанд 14421 холбогдогчтой 21113 хэргийг хүлээн авч шалгаснаас 10460 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4873 хэргийг яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг үүсгэн 5674 хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлтэй байна. Нийт 10653 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 8022 холбогдогчтой 5610 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх, 2152 холбогдогчтой 4631 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлж, 1805 холбогдогчтой 1675 хэргийг нэгтгэн нийт 11916 хэргийг шийдвэрлэж, 4118 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй, мөрдсөн хэргийн 56.4 хувийг шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, иргэдэд учирсан 334.2 тэрбум төгрөгийн хохирлоос 142.0 тэрбум төгрөгийг буюу 42.5 хувийг нөхөн төлүүлж, 76.4 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна.

Эрэн сурвалжлалтын чиглэлээр 2017 онд нийт 27746 хүн, мал, эд зүйл, 4301 оргодол этгээд, хэн болох нь тодорхойгүй 100 цогцсыг бүртгэн эрэн сурвалжилснаас 9811 хүн, мал, эд зүйл, 3160 оргодол этгээд, 84 цогцсыг хэн болохыг олж тогтоон, одоо 17935 хүн, мал, эд зүйл, 1141 оргодол этгээд, 16 цогцсыг хэн болохыг олж тогтоохоор эрэн сурвалжлах ажиллагаа явуулж байна. Аман зургаар 349 хүн эрэн сурвалжилж зарласнаас 37 олж тогтоон, 312 үргэлжлүүлэн эрэн сурвалжилж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 461 дүгээр ангид энэ оны 12 дугаар сарын 20-ны байдлаар эрэгтэй 265, эмэгтэй 13, насанд хүрээгүй 12, нийт 290 яллагдагч цагдан хоригдож байгаагаас гадаадын харьяат 7 иргэн /БНСУ-ын 1, БНВУ-ын 2, ОХУ-ын 1, БНХАУ-ын 3/ байна. Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 137 яллагдагч өлсгөлөн зарласан байна.

Хэрэг бүртгэх албаны чиглэлээр: 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 23570 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь цагдаагийн байгууллагын нийт хүлээн авч шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 67.9 хувийг эзэлж байна. Хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 22010 буюу 93.4 хувийг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 5576 буюу 25.4 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн, 16248 буюу 73.8 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, 186 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу бусад албадад шилжүүлж, ажиллагаанд 1560 гомдол, мэдээлэл байна.

Энэ хугацаанд 5576 хөнгөн гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 496 нэгж буюу 8.2 хувиар буурсан, бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 2648 хэргээс 1644 хэргийг сэжигтэн этгээдийг олж тогтоосноор хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 62.1 хувьд хүрсэн нь урьд оны мөн үеэс 2.2 хувиар өссөн дүнтэй байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас 6.3 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 4.3 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь 69.1 хувьд хүрч, урьд оны мөн үеэс 4.7 хувиар өссөн. үзүүлэлттэй байна.

Шинэчлэн батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс зөрчлийн шинжтэй 18254 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 4242 нь зөрчлийн хэрэг нээж, 797 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 8587-г хүлээн авахаас татгалзаж, хялбаршуулсан журмаар 3762 шийдвэрлэж ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр: Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд бүртгэгдсэн нийт хэргээс согтуугаар үйлдэгдсэн

хэрэг 5507 бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 1080 нэгжээр буюу 19.6 хувиар буурч, гудамж талбайд 6367 гэмт хэрэг үйлдэгдсэн нь 16.2 хувиар, олон нийтийн газарт 4551 гэмт хэрэг үйлдэгдсэн нь 18.6 хувиар тус тус өссөн байна.

Тайлангийн хугацаанд 1204.950 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өссөн, зөрчил гаргасан 1171.070 хүн, 44 албан тушаалтан, 775 аж ахуйн нэгж, байгууллагад 36.237.591.600 төгрөгөөр торгох, 26.907 хүнд эрх хасах, 10.369 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 86.497 хүнийг эрүүлжүүлэн, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо, эмчилгээний төвтэй хамтран архи хэтрүүлэн хэрэглэгч иргэдийг үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж, архины албадан эмчилгээнд 404, сайн дурын эмчилгээнд 2336 иргэнийг хамруулж, тэдэнд архидан согтуурах, мансуурахын хор уршиг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж ажилласан.

Үйлдвэрийн бус хуурамч, согтууруулах ундааг газар дээр нь шалгах, илрүүлэх чиглэлээр онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдвэрлэх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж, таслан зогсоох, цаашид хяналт тавих ажлын үр дүнг ахиулах зорилгоор 15 ширхэг онцгой албан татварын тэмдэг шалгах төхөөрөмжийг шийдвэрлэн, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг ахиулах зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээ явуулах аргачлал” гарын авлагыг боловсруулж, 3000 ширхэгийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиас суллагдсан 566 хүнд захиргааны хяналт тогтоон, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хяналтад байгаа Монгол улсын иргэдийн гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдгэлзүүлэх, гадаад улсын иргэдийг Монгол улсаас гарахыг түдгэлзүүлэх саналыг харьяа хяналтын прокурорт хүргүүлэн, хилийн хориг тогтоолгох арга хэмжээ авагдсан иргэдийн бүртгэл судалгааг эрэн сурвалжлах “ASAP” санд “Хилийн хоригийн бүртгэл” хэсэгт оруулж, хяналт тавин ажиллаж байна.

Галт зэвсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/196 дугаар тушаалаар “Зэвсэг 2017”, “Цагдаагийн байгууллагын 2017 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.1.4-р заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор баталсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлын хүрээнд “Цахим тоглоом” тусгай арга хэмжээг улсын хэмжээнд тус тус зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх /код 408/ журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр тус албанаас зарим аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс зохион байгуулж байгаа ажлыг шалган зааварчилж, үнэлэлт, дүгнэлт өгч, ажлын чиглэл хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөл”-ийн энэ оны 4 дүгээр хуралдаанд “Цагдаагийн байгууллагын эргүүл, хяналт шалгалтын өнөөгийн байдал, анхаарах асуудал”, “Эргүүлийн үйл ажиллагааны стандартыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх асуудлын талаарх танилцуулга”-ын мэдээллийг бэлтгэж, хуралдаанд танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн үед санал авах байр, саналын хуудас хүргүүлэх болон зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах үеийн хамгаалалтад ажиллах алба хаагчдыг томилон ажиллуулав.

Улсын хэмжээнд 1983 хэсгийн хороодод 2805 алба хаагч үүрэг гүйцэтгэхээс Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дорнод, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудын санал авах байрны хамгаалалтад нэмэгдлээр 165 алба хаагчийг Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс, Орхон аймгийн цагдаагийн газраас томилон ажиллуулж, Сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсэгт заасны дагуу шилжилт хийлгүүлэн сонгох эрхээр хангасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/167 дугаар тушаалаар “Хэсгийн байцаагч-2017” тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Төв аймаг дахь цагдаагийн газарт зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс шалгарсан шилдэг 38 хэсгийн байцаагчаас хууль, эрх зүй, гадаад хэл, компьютерийн мэдлэг, эсээ бичлэг, цагдаагийн алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт, албаны галт зэвсэг хэрэглэх, автомашин, мотоцикль жолоодох ур чадвараараа өрсөлдсөнөөс Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Батболд, Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Г.Хатанбаатар, Төв аймаг дахь цагдаагийн газрын хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч С.Цэрэндорж нар эхний байруудад шалгарч, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Сар шинийн “Битүүний өдөр”-ийн барилдаан, Гандантэгчилэн хийдийн хурал, төр, засгийн тэргүүнүүдийн золголт, ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, “Дүнжингарав-2017”, Хөвсгөл, Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан хаврын хурдан морины уралдаан, гадаад улсын зочид төлөөлөгчдийн айлчлал болон олон улсын чуулга уулзалт зэрэг нийт 2624 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 59345 алба хаагч, 6373 автомашин, 58479 тусгай хэрэгсэлтэйгээр 42499 цагийн, 127 удаагийн жагсаал, цуглааны хамгаалалт, зохицуулалтад давхардсан тоогоор 4800 алба хаагч, 330 автомашинтайгаар 2408 цагийн үүргийг тус тус гүйцэтгэсэн.

Нийт зохион байгуулагдсан 127 удаагийн жагсаал, цуглааны 78 буюу 61.4 хувь нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу зохион байгуулагчид сум, дүүрэг, нийслэлийн Засаг даргад хүсэлтээ өгч бүртгүүлэн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд зохион байгуулсан.

Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектуудын хамгаалалтыг батлагдсан орон тооны хүч хэрэгслээр дүрэм, стандартын дагуу зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 1727885 хүн, 402996 тээврийн хэрэгслийг тус тус шалган нэвтрүүлж, 377001 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, захиргааны зөрчил гаргасан 29 иргэнийг түр саатуулж, хуулийн дагуу шалгаж, шийдвэрлэсэн байна.

“Объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журам”-ыг Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2017 оны А/16, А/10 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлсэн.

Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин нийслэлийн 2 дүүрэг, 6 аймгийн 27 сумын нутаг дэвсгэрт 529 удаа гарч, 6954 толгой мал өвчилснөөс 6517 толгой малыг устгасан байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг үндэслэн хорио цээрийн дэглэмийг сахиулахаар 218 алба хаагч, онцгой байдлын 345 алба хаагчтай хамтран ажилласан байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Монгол Улсын хэмжээнд 2017 онд 42 шүүхийн байранд 119 шүүх хуралдааны танхим ашиглагдаж байгаагаас улсын дээд шүүхийн байрны хамгаалалтыг Төрийн тусгай хамгаалалтын газраас хэрэгжүүлж, цагдаагийн байгууллага 41 шүүхийн байрыг 24 цагийн хамгаалалтад аван ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2016 оны байдлаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил болон “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүтэц, нэгж, орон тоо, нөхцөл байдлын талаарх мэдээллийг бэлтгэн Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд эрүүгийн 21297, иргэний 48038, захиргааны 6640 нийт 75629 шүүх хуралдаан товлогдсоноос эрүүгийн 21143 буюу нийт товлогдсон хуралдааны 99 хувьд, иргэний 27711 буюу нийт товлогдсон хуралдааны 57 хувьд, захиргааны 4070 буюу нийт товлогдсон хуралдааны 61 хувьд нийт 53038 шүүх хуралдааны журам сахиулж, шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж 2703-г хүлээн авснаас 2703 шийдвэр, захирамжийг буюу 100 хувийг шийдвэрлэн цагдан хорих байрнаас шүүхийн байр руу 4641 яллагдагчийг, шүүхийн байрнаас 6015 шүүгдэгчийг цагдан хорих байранд, нийт 10656 хүнийг хуяглан хүргэж ажилласан байна.

Замын хөдөлгөөний хяналт, зохицуулалтын чиглэлээр: Тайлангийн хугацаанд Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1515 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 258 нэгжээр буюу 14.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Энэ хугацаанд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 923985 зөрчлийг илрүүлж, 21.686.301 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 23 хүнийг баривчилж, жолоо барих эрхийг хасч, 25316 хүнийг торгож, жолоо барих эрхийг хасч, 11345 хүнийг баривчилж арга хэмжээ авсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сар шинэ”, “Согтуу”, “Гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Хамгаалах бүс”, “Хүүхэд-Явган зорчигч, хариуцлага 2017”, “Улсын дугаар”, “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялын хэрэгжилт”, “Татвар”, “Даатгал”, “Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Тусгай дуут гэрэл дохио”, “Хүүхэд аюулгүй орчин”, “Нийтийн тээвэр”, “Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл”, “Мотоцикль”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, Оюутан тээвэр-2” зэрэг 212 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Замын хөдөлгөөний удирдлагын төв нь хурд хэтрүүлсэн 25324, гэрэл дохио зөрчсөн 16700, нэгдүгээр эгнээгээр зорчсон 178455, түр зогсох журам зөрчсөн 68629, хяналтын үзлэг тооллогод хамрагдаагүй 2571, нийт 323546 зөрчлийг илрүүлэн ажилласан.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг, ослын улмаас 874 хүн гэмтэж, 317 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмтсэн хүний тоо 80 буюу 8,4 хувиар буурч, нас барсан хүн 12 буюу 3,9 хувиар өссөн байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас иргэн аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 26,328,910,82 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Ухаахудаг уурхайгаас Гашуун сухайт хилийн боомт хүртэлх 247 км автозамд улс хоорондын ачаа тээвэрлэж байгаа жолооч, иргэдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мессежийг “Юнител” групптэй хамтран 2 сарын хугацаанд 4 удаагийн давтамжтайгаар хүргэсэн.

Авто тээврийн үндэсний төвтэй хамтран “Онлайн” цахим хурлыг энэ оны 02 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, 21 аймгийн Замын цагдаагийн тасаг /хэсэг/-ийн дарга, ахлах зохицуулагч, Авто тээврийн төвийн болон салбарын дарга нарт улсын болон олон улсын чанартай замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хяналт шалгалтаа сайжруулах талаар үүрэг, ажлын чиглэл өгсөн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хорооны ажлын хэсгээс Улаанбаатар-Дархан чиглэлийн зам, тээврийн осол, хэрэг ихээр гардаг цэгүүдийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, олон улсын чанартай нэгдүгээр зэргийн сөрөг хөдөлгөөнтэй, дөрвөн эгнээтэй, цемент-бетонон хучилттай болгох, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл /тэмдэг заалт, хэвтээ тэмдэглэл, хайс хашилт, нэмэлт тоноглол/-ээр иж бүрэн тохижуулж, олон улсын жишигт нийцүүлэх, хяналт, шалгалтын ажилд зориулан 30 ширхэг хурд хэмжигч болон иж бүрэн хяналтын цэг /пост/ байгуулах шийдвэрийг гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/170 дугаар тушаалаар цагдаагийн хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, албадын хамтын ажиллагаа, алба хаагчдын ажиллах арга, хэлбэрийг өөрчилж, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулагдан холбогдох судалгааг хийж ажилласнаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудын ашиглаж буй 13 байнгын хяналтын цэгийг сүлжээнд холбож, камержуулан мөрдөн шалгах чиглэлээр алба хаагчдыг нэмэгдлээр томилон ажиллуулж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын чанартай зам дагуу байрлах 13, орон нутгийн 19 хяналтын цэгийг байнгын ажиллагаатай болголоо.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран замын цагдаагийн албанд бэлэн бусаар торгох 60 ширхэг **CROSSCALL TRAKKER-M1 CORE** төхөөрөмжийг худалдан авч, харьяа нэгжүүдэд хуваарилан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр: Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр биечилсэн хамгаалалтын арга хэмжээ 10, нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник хэрэгслээр хангах арга хэмжээ 3, урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ 5, аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээ 2, тодорхой үйлдлийг хязгаарлах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ 2, нийт 22 арга хэмжээний хүрээнд гэрч 5, хохирогч 7, шүүгч 3, прокурор 2, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-д заасан иргэн 3, хамаарал бүхий этгээд 8, нийт 28 иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллаа.

Хамгаалалтад авагдсан иргэдэд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг тухай бүр үзүүлэн, хохирогчийг шүүх хуралдаанд оролцох үед сэтгэл зүйчийг байлцуулах арга хэмжээ авч ажилласан.

Хамгаалалтад авагдсан иргэний нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор “Монголын Улаан загалмай нийгэмлэг”, “Дэлхийн зөн” олон улсын байгууллага, “Талита ази” төрийн бус байгууллагуудад хүсэлт хүргүүлэн дэмжлэг тусалцаа авч, хамтран ажилласан байна.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа “Мэдээлэл, танилцуулгын систем”, “Дотоод хяналт, аюулгүй байдлын цогц програм хангамж”, “Мөрдөн байцаах албаны 7 хоног бүрийн статистик тайлан”, “Жолооны сургалтын төвийн бүртгэл”, “Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг бүртгэх програм”, “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүртгэл”, “Нийтийг хамарсан арга хэмжээний бүртгэл”, “Жагсаал, цуглааны бүртгэл”, “Хууль бус аргаар байгалийн ашигт малтмал олборлогч иргэдийн хөдөлгөөний бүртгэлийн систем”, “Гадаад болон дотоодод зохион байгуулагдсан сургалтын бүртгэлийн програм хангамж”-ийг боловсруулж нэвтрүүлсэн.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих” програмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, “ECS” програм хангамжид дуудлага, мэдээллийн шийдвэрлэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн газар, хэлтсийн жижүүрийн офицерууд засварлах боломжийг бүрдүүлж, нийслэлийн хэмжээнд 102 дугаарын утсанд дуудлага, мэдээлэл ирэхэд “Дуут дохио” өгдөг болгох, “Статистикийн тайлан боловсруулах” явцад дутуу боловсруулагдсан тайлангуудыг нэгтгэх, хэвлэх, зөрүүтэй баганад бичлэг нэмэх, хасах, эрүүгийн хэрэг, гомдол, мэдээллийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоотойгоор тухайн мэдээллийг засварлах боломжтой програм хангамж, “Patrol” системээс иргэний мэдээллийг регистрийн болон жолооны үнэмлэхний дугаараар хайж, шаардлагатай мэдээллүүдийг ашиглах, тээврийн хэрэгслийг улсын дугаар, арлын дугаараар хайх боломжийг бүрдүүлж, хууль тогтоомж, ЦБҮАЖ /код/, гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэлтэй танилцах,

Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн бүртгэлийн болон статистикийн мэдээ боловсруулах” програм хангамжид нэмэлт засвар, өөрчлөлтүүдийг оруулсан.

Мэдээлэл нэгтгэн боловсруулах чиглэлээр: Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд 29 төрлийн 1,639,602 мэдээ, мэдээллийг оруулан баяжилт хийж ажиллаа.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын эрх бүхий алба хаагчдаас сүлжээ болон шуудангаар ирүүлсэн 38949 ширхэг “Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас”, “Ялтны хувийн хэрэг”-ээс хуулбар авах хүсэлт гаргасан 1951 албан бичгийг бүртгэн хүлээн авч, 2562 хүний 3895 ялтны хувийн хэргээс 33304 хуудас шаардлагатай материалыг хуулбарлан өгч, эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн 2804 албан бичгийн дагуу 67383 иргэний лавлагааг гарган өгсөн байна.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулга, ажлын чиглэл, албан бичиг, зөвлөмж, санал, хүсэлт, судалгаа авах, сургалт хийх, материал ирүүлэх талаар албад, нэгжээс ирүүлсэн нийт 6255 хуудас бүхий 1117 мэдээллийг хүлээн авч файл хэлбэрт шилжүүлэн судалгаа-мэдээллийн сан бүрдүүлж ажиллаа.

Монгол Улсын Ерөнхий сайдад 53, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад 65, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2, УИХ-ын дэд даргад 2, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 125, дэд сайдад 2, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 24, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 6, ХЗДХЯ-ны ГХУСАЗЗАА-нд 2, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад 1, ХНХСайдад 1, Гадаад харилцааны яаманд 3, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргад 1, УЕПГ-т 4, СЕХ-ны нарийн бичгийн даргад 1, Онцгой байдлын газарт 1 удаа тус тус нийт 282 удаа цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, танилцуулгыг хүргүүлсэн.

Статистик, мэдээллийн сангаас нийт 73 байгууллага, албан тушаалтанд 95 төрлийн судалгааг бэлтгэн гаргаж хүргүүллээ.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр: Тайлангийн хугацаанд иргэд, байгууллагаас нийт 911615 дуудлага, мэдээллийг тусгай дугаарын утсуудаар хүлээн авч, холбогдох газруудад дамжуулсан байна. Үүнд: Архидан согтуурсантай холбоотой дуудлага 116137, хэв журмын зөрчил 263115 гэмт хэргийн талаарх мэдээлэл 38143, сураггүй алга болсон хүний талаарх мэдээлэл 8366, олдсон хүүхэд /хүн/-ийн талаарх мэдээлэл 6881, гадаадын иргэнтэй холбоотой 889, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 34248, бусад 33092, сонгуультай холбоотой 690, зам тээврийн ослын 117306 мэдээ мэдээлэл бүртгэгдсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн <http://102.police.gov> дотоод цахим хуудасны “МШУТ-ийн ШУХ 102 анхааруулж байна” хэсэгт хулгайлах гэмт хэргийн дуудлагын шийдвэрлэлтийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг олон давтамжтай ирүүлсэн утасны дугаар, хаягийн 1383 мэдээллийг байршуулж ажилласан.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн 108 дугаарт хүүхдийн амь нас хохирсон болон хүүхдийн эрх зөрчигдсөн тухай 850 мэдээллийг дамжуулж, тус төвөөс 102 тусгай дугаарт 1155 дуудлагыг хүлээн авч хамтран ажиллав.

Мэргэжил, хяналтын чиглэлээр: Бүртгэл, хяналтын төвийн Мэргэжил, хяналтын хэсгээс тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургуулийн сонсогчдоос мэргэжлийн шалгалт авах он, сар, өдөр, сургууль, дамжааны нэр, шалгалт авах ангилал, байрлал зэрэг мэдээллийг багтаасан шалгалтын хуваарийг тус төвийн үйлчилгээний танхим, www.facebook.com/licensapolice цахим хуудсанд байршуулж, холбогдох мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 39519 хүнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 14993, 30967 хүнээс автодромын шалгалт авснаас 19900, 12625 хүнээс замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт авснаас 11126 хүн тус тус тэнцэж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгосон.

Хууль зүйн сайдын 2015 оны А/186 дугаар тушаалаар баталсан Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх журмын дагуу “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр”-өөр “Хатан Эрдэнэ” төрийн бус байгууллага тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан, зөрчлийн оноо дууссан жолооч нарт 2 төрлийн танхимын сургалтыг лекц, видео хэлбэрээр 6 цагийн сургалтыг өдөр бүр зохион байгуулж, 7951 хүнийг хамруулан давхардсан тоогоор 31682 иргэнээс цахимаар шалгалт авч, 11415 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээсэн.

Жолооны эрхийн үнэмлэх нөхөн авах, солиулах, жолоодох эрхээ сэргээлгэх зэргээр хандсан иргэдээс Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байсан 40 этгээдийг олж тогтоон холбогдох албад, нэгжүүдэд хүлээлгэн өгсөн.

Тус төвийн үйлчилгээний танхимаар 143221, Дүнжингарав худалдааны төв дэх “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр 36481, нийт 179702 иргэнд үйлчилсэн.

Зөвшөөрөл, хяналтын чиглэлээр: Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар худалдааны төвөөс галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 547, гадаад орнуудаас галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 117, улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 105 иргэнд, мөн хуулийн 20 дугаар зүйлийн дагуу тэмцээн, уралдаанд оролцох зорилгоор улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх, гаргах зөвшөөрөл хүссэн спорт, буудлагын 28 холбоо, ан агнах зорилгоор улсын хилээр галт зэвсэг түр нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 113 иргэнд тус тус холбогдох зөвшөөрлийг олгосон байна.

Галт зэвсэг худалдаж авах, улсын хилээр нэвтрүүлэх хүсэлт гаргасан 769 иргэний ял шийтгэгдсэн эсэх лавлагаанд холбогдох судалгааг хийсний дээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хураагдсан 543 ширхэг галт зэвсэг, 28359 ширхэг сумыг хүлээн авч, дугаарлан бүртгэлд авсан.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах санал авахаар хандсан 66 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч хянан, шаардлага хангасан 47 аж ахуйн нэгжийн дэмжих саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж, шаардлага хангахгүй 19 аж ахуйн нэгжид татгалзсан тухай хариу өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаал /Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам/-ын дагуу хугацаа дууссан болон шинээр зөвшөөрөл хүссэн 978 байгууллага, албан тушаалтны хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянан 692 байгууллага, албан тушаалтны 1569 тээврийн хэрэгсэлд 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар зөвшөөрөл (Улаан 521, Хөх 86, Хөх-Улаан 94, Ногоон 204, Шар 661) олгожээ.

Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын бүртгэлийн нэгдсэн сан SAS /security agency services/-д баталгаажсан 298 байгууллагын материалыг хянаж, бүртгэлийн гэрчилгээ олгов.

Архивын үйл ажиллагааны чиглэлээр: Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, “Албан хэрэг хөтлөлтийн бүртгэл хяналтын програм”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашиглах, “Байгууллагын архивын үндсэн заавар”, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн

стандарт /MNS 5140:2011/", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Архив албан хэрэг хөтлөх /код 120/ журам"-ын хэрэгжилтийг хангах, "Able cloud" цахим системийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн урсгал, бичиг баримтын давхардал зэрэгт тавих хяналтыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг хэрэгжүүлэн ажилласан.

Цагдаагийн байгууллагын төв архивт хандсан 1433 албан бичгийн дагуу 832 архивын лавлагаа гаргаж, 1334 иргэнд архивын лавлагааг олгож, 832 алба хаагчийн лавлагааг тухайн харьяалах газар, хэлтсүүдэд хүргүүлж, лавлагаа гаргахад давхардсан тоогоор 1341 хөмрөгийн 7116 хадгаламжийн нэгж, 1624896 хуудас баримтад шүүлт хийж, архивын 2 дугаар сангаас 427, Хүний нөөц, сургалтын хэлтсээс 704, нийт 1131 боловсон хүчний хувийн хэрэг материалыг ашиглаж, захиалгаар 1433, албан бичгээр 832, нийт 2265 лавлагаа гаргасан байна.

Архивын баримт, 56 өргөдөл, 44 захиалга, 88 албан бичгийг хүлээн авч, давхардсан тоогоор 65 хөмрөгийн 2 дансны 290 хадгаламжийн нэгжийн 63437 хуудас баримтаас шүүлт хийж, 975 хуудас баримтыг хуулбарлан баталгаажуулж үйлчиллээ.

Хэвлэл мэдээллийн чиглэлээр: Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Амрыг эрье" нэвтрүүлгийн 90 дугаарыг бэлтгэн МҮОНТ-ийн 1, 2 дугаар сувгаар 7 хоног бүрийн пүрэв, баасан гарагт 15 минутын хугацаатайгаар олон нийтэд хүргэсэн.

Тайлангийн хугацаанд www.police.gov.mn сайтын "Мэдээ мэдээлэл-Цаг үе үйл явдал" буланд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай холбоотой 458 мэдээ нийтэлсэн.

Хэвлэл мэдээллийн төв /www.facebook.com/policemng/ фэйсбүүк хуудаст өдөр тутам тогтмол текст болон видео, фото мэдээ бусад мэдээллийг 1139 /мэдээ, ярилцлага, нийтлэл, видео мэдээ/ нийтлэгдсэн нь давхардсан тоогоор 8.983.326 хүнд хүрч, 46658 уншигч бусадтай хуваалцаж, 11116 хүн сэтгэгдэл үлдээсэн байна. Фэйсбүүк хуудасны дагагчийн тоо 61047, өдөрт дунджаар 50995 хүн хандаж, мэдээ мэдээлэл тогтмол авдаг.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 206 мэдээллийг policemongolia6@gmail.com, presscenter@police.gov.mn хаягаар хүлээн авч боловсруулан, төвийн цахим сайт, фэйсбүүк хуудсаар сурталчилж, олон нийтэд хүргэсэн.

Хэвлэл мэдээллийн төвөөс цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран 12 удаа хэвлэлийн хурал зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.

Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны "Цагдаагийн байгууллагын спортын аварга шалгаруулах тэмцээний төрөл, нэгдсэн зааврыг батлах, зохион явуулах ажлын хэсэг байгуулах тухай" Б/30 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энэ оны 03 дугаар сарын 09-нөөс 12 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл зохион байгуулагдаж, тэмцээнд давхардсан тоогоор 451 байгууллагын 3455 тамирчин, алба хаагч оролцсон. Тэмцээний нэгдсэн дүнг төвийн болон орон нутгийн цагдаагийн байгууллагуудаар тус тусад нь гаргаж, байр эзлүүлэн тэргүүн байранд шалгарсан анги байгууллагад шилжин явах "Хаш чулуун цом" гардуулсан.

"Эрүүл агаар-эм" спорт явган аялалд Улаанбаатар цагдаагийн хүрээний 641 алба хаагчийг хамруулсан ба Цагдаагийн байгууллагын "Их сорилго"-ыг энэ оны 07 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан.

Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд төв, орон нутгийн 32 алба хаагч, үндэсний сурын харваанд 16 алба хаагчийн бэлтгэлийг хангуулан оролцуулсан.

Цагдаагийн байгууллагын “Сүлд” чуулгаас “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, 16 газар, хэлтсийн 1411 алба хаагчийг хамруулж, үлээвэр хөгжмийн бүрэлдэхүүн тайлан тоглолт 3, хандивын тоглолт 2, бүрэн хэмжээний тоглолт 16 найруулан, гоцлол бүтээл, бүжгийн бүтээл тус бүр 2, хөгжмийн зохиол 6, маршийн зохиол 7, дуулаачийн 10, нийт 27 урлагийн бүтээлийг шинээр бүтээж, олон нийтийн хүртээл болгосон байна.

Тайлангийн хугацаанд Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан жүдо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд “Хүч” спорт хорооны дасгалжуулагч, Монгол Улсын гавьяат тамирчин, цагдаагийн дэслэгч М.Уранцэцэг мөнгөн медаль, АНУ-ын Лос-Анжелос хотноо зохион байгуулагдсан Дэлхийн цагдаагийн тоглолтод Монгол Улсын Цагдаагийн байгууллагын баг тамирчид спортын найман төрөлд өрсөлдөж 14 алт, 12 мөнгө, 7 хүрэл, нийт 33 медаль тус тус хүртсэн, Чингис хааны одонт, Монгол Улсын гавьяат жүжигчин, цагдаагийн ахмад Ганбаатарын Ариунбаатар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Уэльс Улсын нийслэл Кардиф хотноо зохион байгуулагдсан “BBC Cardiff Singer of the Word” уралдаанд оролцож, “Романс” төрөлд тэргүүн байр, “Ария” төрөлд шилдэг дуучнаар шалгарсан зэрэг явдал нь цагдаагийн байгууллагыг сурталчилсан үйл явдал боллоо.

Гурав. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар

3.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг

Нийт 192618 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсанаас гэмт хэргийн шинжтэй 78722, зөрчлийн шинжтэй 113896, гэмт хэргийн шинжтэй нийт гомдол мэдээллээс 33251 буюу 42.6 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44393 буюу 56.9 хувьд нь хэрэг нээхээс татгалзан, 406 буюу 0.5 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс 27799 буюу 24.6 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 50038 буюу 44.3 хувийг нь газар дээр нь торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэн, 24584 буюу 21.7 хувьд нь зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 717 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 1440 буюу 0.7 хувь нь хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 64.5 хувийг 5 хоногт, 35.5 хувийг 6 түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 78.8 хувийг 3 хоногт, 21.2 хувийг 4 ба түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд 32259, нийслэл хотод 68.0 хувь буюу 21947, орон нутагт 31.8 хувь буюу 10273, бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ 0.2 хувь буюу 39 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 5092 буюу 18.7, нийслэлийн хэмжээнд 4038 буюу 22.5, орон нутгийн хэмжээнд 1051 буюу 11.4, бусад газар /хилийн чанадад/-ын хэмжээнд 3 буюу 8.3 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг урьд оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 48.8 хувиар, хүнд гэмт хэрэг 4.8 дахин өсч, хүндэвтэр гэмт хэрэг 56.3, онц хүнд гэмт хэрэг 49.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг, хэргийн төрлөөр нь авч үзвэл: Хүнийг алах 189, хүнийг амиа хорлох нөхцөлд хүргэх 470, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 1233, хүрээлэн буй орчны эсрэг 330, хулгайлах 11771, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 8812, залилах 2996, хүчиндэх 376 тус тус бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 8.6 хувиас 2,3 дахин өсч, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг 727, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1525 бүртгэгдэж, урьд оны мөн үетэй харьцуулахад 14.5-49.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 35.6, нийслэлд 28.8, орон нутагт 54.8 байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 28.3, нийслэлд 32.6,

орон нутагт 16.9 хувиар тус тус буурсан ба нийт гэмт хэрэгт 18131 хүн холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 23.8 хувиар буурсан.

Гэмт хэргийн улмаас 86 хуулийн этгээд, 37173 иргэн хохирч, үүнээс 1416 хүн нас барж, 10816 хүн гэмтсэн нь урьд оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 536 буюу 60.9 хувиар өсч, гэмтсэн хүн 411 буюу 3.9 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 198073.2 сая төгрөгийн хохирлын 74508.2 сая төгрөг буюу 37.6 хувийг нөхөн төлүүлж, 36668.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн.

3.2. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн захиргааны зөрчил

Нийт 1.327.017 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 288967 буюу 27.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 364151 буюу 27.4 хувь нь орон нутагт, 962866 буюу 72.6 хувь нь нийслэлд бүртгэгджээ.

Зөрчил гаргасан 1289466 иргэн, 44 албан тушаалтан, 823 хуулийн этгээдийг 40.3 тэрбум төгрөгөөр торгох, 25339 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 11345 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1.314.831 буюу 99.1 хувьд нь цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, 12.186 буюу 0.9 хувьд нь шүүгч тус тус шийтгэл ногдуулсан байна.

Тайлангийн хугацаанд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 86.497 хүн эрүүлжүүлэгдсэнээс 52.301 буюу 60.5 хувь нь нийслэлд, 34.196 буюу 39.5 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бөгөөд тэдний 5.521 буюу 6.3 хувь нь эмэгтэй, 271 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна. Нийт 431 хүнийг архины албадан, 2.668 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулан ажилласан.

Дөрөв. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар

Цагдаагийн байгууллагад 2017 оны төсөвт урсгал санхүүжилтийн зардалд 156.1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 1.4 тэрбум төгрөг, нийт 157.6 тэрбум төгрөгийг баталсан ба үүний 109,7 тэрбум буюу 69,7 хувь нь цалингийн, 2,2 тэрбум буюу 1,4 хувь нь ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын, 1,4 тэрбум буюу 0,9 хувь нь хөрөнгө оруулалтын, 44,1 тэрбум буюу 28 хувь нь урсгал зардал байна.

Төсвийн тодотголоор алба хаагчдын цалингийн зардалд 2,4 тэрбум, Монгол Улсын Ерөнхий прокурорын А/57 дугаар тушаалаар батлагдсан мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагын дагуу засвар, техник хэрэгслийн зардалд 650,3 сая, Цагдаагийн албаны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд эхний ээлжид шаардагдах 3.0 тэрбум, Хар тамхи орж ирэх магадлалтай хил дагуу аймгуудад 13 ширхэг УАЗ Пургон /нэг бүрийн үнэ 31,0 сая төгрөг/ автомашин худалдан авахад 400,0 сая, сахилга хариуцлага, үр дүнгийн урамшуулал 2,9 тэрбум, нийт 9,4 тэрбум төгрөгийг тус тус шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас Ховд аймаг дахь цагдаагийн газрын эрүүлжүүлэх байрны засварт 50,0 сая, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газрын эрүүлжүүлэх байр барихад 80,0 сая, тэтгэвэрт гарсан алба хаагчдад олгох тэтгэмжийн зардалд 80,0 сая, алба, нэгж, нутаг, дэвсгэр хариуцсан 31 цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх байрны эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн урсгал зардалд нийт 204,6 сая, нийт 414,6 сая төгрөгийг тус тус шийдвэрлэсэн.

Тайлангийн хугацааны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 153,0 тэрбум төгрөгийн төсвийн урсгал санхүүжилт, 5,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлого болох гэрээт, эрүүлжүүлэх, тээврийн хэрэгсэл түр саатуулах, хэвлэх хэсгийн орлогоор 9,0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилтээр 120,4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу хөдөө орон нутагт ажиллаж байгаа 75 алба хаагчид 1,2 тэрбум төгрөгийн урамшуулал, Цэргийн албаны тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 213 алба хаагчид олгох 6,3 тэрбум төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосон.

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан цагдаагийн газар, хэлтэс, төв, тасаг 61 нэгжийн орон тоо, цалингийн сангийн судалгаа тооцоо, нийт төсвийн тооцоог гаргаж, хуулийг хэрэгжүүлэх явцад батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй, өр авлага үүсгэхгүй байх чиглэлийг баримтлан ажиллаа.

Энэ онд цагдаагийн 65 байгууллагын 9238 алба хаагчид 74969 дүрэмт хувцасны нэгдсэн хангалтыг хийж, 23 байгууллагын 105 алба хаагчдад 279 дүрэмт хувцасны захиалгын хуудас олгож, нийт 3,7 тэрбум төгрөгийн хангалтыг хийсэн.

Цагдаагийн албанд ашиглах 5670 ширхэг, 239,0 сая төгрөгийн тусгай хэрэгсэл, бараа материалыг орлогод авч, цагдаагийн алба, газар, хэлтэст 12732 ширхэг, 379,0 сая төгрөгийн хангалтыг хийсэн.

Хэвлэх хэсэгт 7261 ширхэг 33,5 сая төгрөгийн материал орлогод авч, нийт 1,225,690 ширхэг 69,1 сая төгрөгийн хэвлэмэл хуудсыг хэвлэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 268 автомашин, Нийслэлийн цагдаагийн газрын хөрөнгөд бүртгэлтэй 234 автомашин улсын хэмжээнд үүрэг гүйцэтгэж ажиллаа.

Цагдаа, Дотоодын цэргийн алба хаагчдын 2017 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, өвчлөлийн судалгаанд нийт 59 байгууллагын 7598 алба хаагчийн судалгааг ирүүлсэн ба судалгаанд оролцогчдын 69 хувь буюу 5249 алба хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн алба хаагч 337, цагдаагийн алба хаагчийн ар гэр 734, цагдаагийн ахмад ажилтан 232, энгийн 170, урилгаар 100, нийт 1573 сувилуулагчийг “Сүүж уул” сувилалд хүлээн авч, зохих эмчилгээ, сувилгаанд хамруулсан байна.

Тав. Дүгнэлт

-Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, 2017 онд дэвшүүлсэн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх”, “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх”, “Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах” гэсэн зорилтуудыг биелүүлж ажиллаа.

-Монгол Улсын Их Хурлаас Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Дотоодын цэргийн тухай хуулийг батлан, мөрдөж эхэлсэн бөгөөд алба хаагчдын нийгэм, улс төр, эдийн засаг, хууль зүйн баталгааг хангах эрх зүйн үндэслэлийг шинэ түвшинд төрийн тусгай алба болгосноороо ач холбогдолтой төдийгүй түүнд нийцүүлэн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүргийн давхардлыг арилгаж, бүтэц орон тоог шинээр баталсан нь байгууллагыг хөгжүүлэх, түргэн шуурхай, иргэдэд чирэгдэл, ялгаваргүй, тэгш шударгаар үйлчлэх, иргэд-олон нийтийн дэмжлэг туслалцаанд тулгуурлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон гэж дүгнэж байна.

-Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 5092 хэргээр буюу 18.7 хувиар, нийслэлд 4038 хэргээр буюу 22.5 хувиар, орон нутагт 1051 хэргээр буюу 11.4 хувиар тус тус өсч бүртгэгдсэн байна.

Олон улсын жишгээр гэмт хэргийн өсөлт, бууралтыг хэмжих гол шалгуур нь тухайн орны эдийн засгийн хөгжил, ажилгүйдлийн түвшин, хүн амын орлогын үзүүлэлт гэж үздэг.¹

Үндэсний статистикийн газрын судалгаагаар манай улсын хүн амын 60 орчим хувь нь дунджаас доогуур орлоготой, ядуурлын түвшин тогтмол өсөлттэй, үүнээс үүдэн иргэдийн худалдан авах чадвар, орлого буурч төвийн бүс нутгуудад ажилгүйдэл, хил орчмын бүс нутгуудад ашигт малтмал, уул уурхай дагасан төвлөрөл бий болсон гэж дүгнэсэн байна.

Улсын хэмжээнд хүнийг амиа хорлох нөхцөлд хүргэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, эрүүл мэндэд халдах, залилах, хүчиндэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг ахуйн хүрээний гэмт хэрэг 6.9 хувиас 3.6 дахин өсөлттэй байгаа нь ядуурал, ажилгүйдэл гэх мэт дээр дурдсан үндсэн шалтгаантай холбоотой гэж дүгнэх үндэслэлтэй юм.

Мөн сүүлийн 5 жилийн дунджаар цагдаагийн байгууллагын хүлээн авсан нийт гомдол мэдээллийн 40 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн шийдвэрлэж байсан бол 2017 оны 7 дугаар сарын тухайд уг үзүүлэлт огцом өсч, 2835 буюу 62.2 хувьд хүрсэн.

Эрүүгийн хуулиар урьд нь материаллаг бүрэлдэхүүнтэй байсан зарим төрлийн гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилсан, хуулиар тогтоосон гомдол, мэдээллийг 5 хоногийн хугацаанд шалгах болсон нь хэргийн нөхцөл байдлыг бүрэн судалж, шийдвэр гаргахад хүндрэл учирч, цаашид үйлдэл холбогдлыг тогтоох, шалгалтын ажиллагаа явуулахын тулд гомдол мэдээллийн дийлэнх хувьд нь “Хэрэг бүртгэлтийн хэрэг” нээн шалгаж байгаа нь гэмт хэргийн статистик тоо мэдээнд нөлөөлсөн гэж дүгнэж байна.

-Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас илрүүлсэн захиргааны зөрчил урьд оны мөн үетэй харьцуулахад 288.967 буюу 27.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх, эргүүл, хяналтын үйл ажиллагааны үр дүн гэж дүгнэж байна.

-Тайлангийн хугацаанд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас гаргасан нийт сахилгын зөрчлийг урд оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн тоо 297 нэгжээр буюу 19 хувиар, холбогдсон алба хаагчийн тоо 312 буюу 19.3 хувиар тус тус буурсан зэрэг үзүүлэлттэй байна.

Зургаа. Санал

-“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.

-Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Цагдаагийн ерөнхий газарт хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж, өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилт, үр дүнг тооцох.

-Цагдаагийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

¹ <https://www.bra.se/bra-in-english/home/publications/archive/publications/2015-06-10-the-clearance-rate-in-sweden-and-in-other-countries.html>

